



ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ НЬ





ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР

ТӨРӨӨС ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ 2027 ОН ХҮРТЭЛ БАРИМТЛАХ БОДЛОГО
2018.06.06

ДЭЭД УРСГАЛ

ДООД УРСГАЛ

ХАЙГУУЛ

ОЛБОРЛОЛТ

ТЭЭВЭРЛЭЛТ

БОЛОВСРУУЛАЛТ

ТЭЭВЭРЛЭЛТ

БОРЛУУЛАЛТ


ЭРХ ЗҮЙН ОРЧИН

МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН
ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬ
2014.07.01

МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН ТОСНЫ
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬ
2005.07.01

БОДЛОГО (УУХҮЯ)

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ (АМГТГ)



Хайгуулын 2 талбай /Хонгор VIII, Чойр XXV/-д шинээр БХГ байгуулах шатанд,

1 талбай /Гурванбаян XXX/ сонгон шалгаруулалтын шатанд,

1 талбай /Шарга III/-н сонгон шалгаруулалт цуцлагдсан,



1 талбай /Давст XXXI/-г нээлттэй

1 талбай /Нэмэгт VI/-д 2009 онд сонгон шалгаруулалт зарлагдсан байсан боловч УИХ-ын 2016 оны 35 дугаар тогтоолоор тус талбайд хамаарах Тост, Тосонбумбын нурууг улсын тусгай хамгаалалтад авч, Засгийн газрын 2017 оны 91 дүгээр тогтоолоор хил заагийг тогтоосноор тус талбайн 50 гаруй хувь хасагдсан тул газрын тосны хайгуулын талбайгаас хассан.



1. Газрын тосны орд ашиглалтыг эрчимжүүлж, олборлолтыг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлын хүрээнд



Тосон-Уул XIX, Тамсаг-XXI, БХГ-97 талбайн нөөцийн тооцооны тайланг 2010-2012 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (ЭБМЗ)-өөр хэлэлцүүлж, газрын тосны нөөцийг “баталгаат” зэрэглэлээр нийт **332.64** сая тонн, “ашиглалтын баталгаат” зэрэглэлээр нийт **43.26** сая тонноор тус тус Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэж, тус ордуудыг



Жич: Хуримтлагдсан олборлолт 2018.12.31-ний байдлаар байна. Үүнд Зүүнбаянгийн ордоос 1950-1969 хооронд олборлосон тосны тоо хэмжээ багтсан болно.




ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



Тамсаг XXI талбай


Байршил: Дорнод аймаг, Халхгол сум
Гэрээлэгч: Петрожайна Дачин Тамсаг ХХК
Ашиглалтын талбай: 209.2 км² (хайгуулын талбайн 2.1%)
Нийт өрөмдсөн цооног: 522,
Олборлолтын цооног: 228
Хоногийн олборлолт: 1300 тонн
Газрын тос: 875 кг/м³, 0.17% хүхэр, 18.9 мПа*с
Хөрөнгө оруулалт: 919.7 сая ам.доллар



Тосон-Уул XIX талбай

Байршил: Дорнод аймаг, Матад сум
Гэрээлэгч: Петрожайна Дачин Тамсаг ХХК
Ашиглалтын талбай: 650 км² (хайгуулын талбайн 8.4%)
Нийт өрөмдсөн цооног: 928
Олборлолтын цооног: 456
Хоногийн олборлолт: 1200 тонн
Газрын тос: 836 кг/м³, 0.1% хүхэр, 5.75 мПа*с
Хөрөнгө оруулалт: 1.9 тэрбум ам.доллар

БХГ-97 талбай



Байршил: Дорноговь аймаг, Сайншанд сум, Зүүнбаян баг
Гэрээлэгч: Доншен Газрын тос (Монгол) ХХК
Ашиглалтын талбай: 239.5 км² (хайгуулын талбайн 4.5%)
Нийт өрөмдсөн цооног: 119,
Олборлолтын цооног: 106
Хоногийн олборлолт: 130 тонн
Газрын тос: 878 кг/м³, 0.12% хүхэр, 29.6 мПа*с
Хөрөнгө оруулалт: 259.1 сая ам.доллар



ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ ХХК-ИЙН
ХООРОНД БАЙГУУЛСАН ПРОТОКОЛ

2011.06.24

Улаанбаатар хот

Энэхүү протоколоор Дорнод аймгийн Тамсагийн сав газрын Тосон Уул-ХИХ, Тамсаг-ХХИ талбайгаас олборлож буй түүхий тосыг борлуулах асуудлыг дараахь байдлаар харилцан тохиролцов. Үүнд:

1. Бүтээгдэхүүн хуваах гэрээний Удиртгал хэсэгт "Монгол Улс нутаг дэвсгэрийхээ байгалийн бүх нөөц баялгийн цорын ганц эзэмшигч бөгөөд Монголын ард түмний ашиг сонирхолд нийцүүлэн байгалийн нөөц баялгаа олборлон боловсруулж, ашиглах эрхтэй" гэж заасны дагуу Петроцайна Дачин Тамсаг ХХК нь БХГ-ний дагуу өөрт ногдох түүхий тосыг тэргүүн ээлжинд Монгол Улсад нийлүүлнэ.
2. Дорнод аймгийн Тамсагийн сав газрын Тосон Уул-ХИХ, Тамсаг-ХХИ талбайгаас олборлож буй түүхий тосыг шинж чанараас нь хамааруулан дэлхийн зах зээлийн үнэд нийцсэн боломжит өндөр үнээр хилийн чанадад борлуулах гэрээг Газрын тосны газар, Петроцайна Дачин Тамсаг ХХК болон худалдан авагч талууд харилцан тохиролцож, Газрын тосны газрын зөвшөөрлийг авсаны үндсэн дээр Петроцайна Дачин Тамсаг ХХК нь худалдан авагч талтай тус гэрээг байгуулна.
3. Монголын Засгийн газарт ногдох түүхий тосыг шинж чанараас нь хамааруулан дэлхийн зах зээлийн үнэд нийцсэн боломжит өндөр үнээр хилийн чанад дахь худалдан авагч талд борлуулах эрхийг Петроцайна Дачин Тамсаг ХХК-д олгов.
4. Талууд түүхий тос борлуулалтын орлогыг сар бүр тооцоо нийлэн, Петроцайна Дачин Тамсаг ХХК Засгийн газарт ногдох орлогыг дараа сарын 25-ны өдрийн дотор Газрын тосны газрын дансанд шилжүүлнэ.
5. Талууд Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу өөрт ногдох тосыг борлуулахтай холбогдон гарах тээвэр, буулгалт, хяналт, халаалт, ус ялгалт болон банкны шимтгэлийн зардлыг бүрэн хариуцна.

ПРОТОКОЛ

2011 оны 9 дугаар
сарын 21-ны өдөр

Улаанбаатар хот

Доншен газрын тос /Монгол/ ХХК болон Газрын Тосны Газар дараахь асуудлуудыг харилцан тохиролцов. Үүнд:

1. Бүтээгдэхүүн хуваах гэрээний Удиртгал хэсэгт "Монгол Улс нутаг дэвсгэрийхээ байгалийн бүх нөөц баялгийн цорын ганц эзэмшигч бөгөөд Монголын ард түмний ашиг сонирхолд нийцүүлэн байгалийн нөөц баялгаа олборлон боловсруулж, ашиглах эрхтэй" гэж заасны дагуу Доншен газрын тос /Монгол/ ХХК нь БХГ-ний дагуу өөрт ногдох түүхий тосыг тэргүүн ээлжинд дэлхийн зах зээлийн боломжит үнээр Монгол Улсад нийлүүлнэ.
2. Доншен газрын тос /Монгол/ ХХК-ийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй БХГ-97 талбай ашиглалтад шилжиж байгаатай холбогдуулан тус компаниас төлөөлөгчийн албаны үйл ажиллагаанд зориулан жил бүр 30.000 ам.долларыг Газрын тосны газарт төлнө.
3. Доншен газрын тос /Монгол/ ХХК-ийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй БХГ-97 талбай ашиглалтад шилжиж байгаатай холбогдуулан тус компаниас орон нутгийн хөгжилд дэмжлэг болгон 40.000 ам.долларыг Дорноговь аймгийн хөгжлийн санд жил бүр төвлөрүүлнэ.
4. Доншен газрын тос /Монгол/ ХХК нь дээрх төлбөрүүдийг 2011 оноос эхлэн жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан шилжүүлнэ.
5. Доншен газрын тос /Монгол/ ХХК нь Дорноговь аймгийн хөгжлийн санд тус компаниас төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах тухай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол болон зарцуулалтын тайланг хүлээн авч, хяналт тавина.
6. Дээрхи төлбөрүүд нь өртөгт тосоор нөхөн төлөгдөхгүй болно.
7. Энэхүү протокол нь Бүтээгдэхүүн хуваах гэрээний салшгүй хэсэг болно.

ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГА

Д. АМАРСАЙХАН

ДОНШЕН ГРУППИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ

СҮН ЮНЖУАН

Монгол Улсын нутаг дэвсгэрээс олборлосон газрын тосыг дотоодын боловсруулах үйлдвэрт тэргүүн ээлжинд нийлүүлэх ажлын хүрээнд:


- Петроцайна дачин тамсаг ХХК-тай 2011.06.02-ны өдөр, Доншен Газрын тос (Монгол) ХХК-тай 2011.10.21-ний өдөр Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу гэрээлэгчид ногдох түүхий тосыг тэргүүн ээлжинд Монгол Улсад нийлүүлэх тухай протоколыг тус тус байгуулсан.
- Тус протокол нь Бүтээгдэхүүн хуваах гэрээний салшгүй хэсэг болно.



Газрын тосны ордын дэд бүтцийг хөгжүүлэх ажлын хүрээнд:


Тосон-Уул XIX талбайгаас
Баянхошуу хилийн боомт
чиглэлийн 210.7 км хатуу
хучилттай авто зам 2018 онд
бүрэн ашиглалтад орсон

Тамсаг XXI талбайн үйлдвэрлэлийн
баазаас Тосон-Уул XIX талбай-
Баянхошууны хилийн боомтын
чиглэлийн замд нийлэх 58.5 км хатуу
хучилттай автозамын барилгын ажил
хийгдэж байна.





ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ



ДБЭХС ТӨХК-ийн томоохон
хэрэглэгчдийн 2017 оны ЦЭХ-
ний түгээлтэд эзлэх хувь

- Дорнод аймгийн айл өрх, ААН
- 'ХХЕМ' ХХК
- Петрочайна Дачин Тамсаг ХХК
- Сүхбаатар аймгийн айл өрх, ААН

- Чойбалсангийн ДЦС-ийн цахилгаан эрчим хүчний түгээлтийн 47%-ийг дангаараа Петрочайна Дачин Тамсаг ХХК эзэлж байгаа ба Тосон-Уул, Тамсагийн ордуудын газрын тосны олборлолтын хэмжээ нь цахилгаан эрчим хүчний хэрэглээнээс шууд хамаарна. Одоогоор тус төслийн хэрэгцээ нь 20 МВт боловч, 11 МВт цахилгаан эрчим хүч нийлүүлж байна.

Чойбалсангийн ДЦС



11 МВт



188.6 км

Тосон-Уул



93.7 км

Тамсаг





Газрын тосны салбарын үйл ажиллагааны үед байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон хөгжил, орон нутгийн хөгжлийг ДЭМЖИХ

Петрочайна дачин тамсаг ХХК

- 2019 онд тус компани байгаль орчинг хамгаалах 40 төрлийн ажилд 2,483,500 ам.доллар зарцуулахаар төлөвлөн, ажиллаж байна.
- 2019 онд тус компани нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор Дорнод аймагт 500 мянган ам.доллар буюу 1 тэрбум 326 сая 500 мянган төгрөгийн урамшуулал олгосон.

Доншен Газрын тос (Монгол) ХХК

- 2019 онд тус компани байгаль орчинг хамгаалах 8 төрлийн ажилд 207,756 ам.доллар зарцуулахаар төлөвлөн, ажиллаж байна.
- 2018 онд Зүүнбаян багт 50 хүүхдийн ортой цэцэрлэг барьж байгуулах ажилд 500 сая төгрөгийн хөрөнгө оруулсан
- 2019 онд Зүүнбаян багийн усан бассейны завсар, шинэчлэлийн ажилд 270 сая төгрөгийн хөрөнгө оруулсан





Газрын тосны салбарын үйл ажиллагааны үед байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон хөгжил, орон

№	Хайгуулын талбай	БХГ-ээр жилд /ам.дол/		2019 оны 9 дүгээр сарын байдлаар		2019 оны үйл ажиллагаа
		Байгаль орчин	Орон нутаг хөгжүүлэх	Байгаль орчин	Орон нутаг хөгжүүлэх	
1	Баянтүмэн XVII	6,000.00	-	56,130\$	-	ЗОГСОНГИ
2	Хөх нуур XVII	40,000.00	50,000.00	387,185,270₮	400,000\$	ЗОГСОНГИ
3	Матад XX	-	30,000.00	464,290.47\$	562,608,000₮	3 цооног
4	Дарьганга XXIV	60,000.00	40,000.00	-	-	ЗОГСОНГИ
5	Сүхбаатар XXVII	250,000.00	75,000.00	35,000\$ 15,000,000₮	246,537,127₮	ЗОГСОНГИ
6	Хэрлэнтохой XXVIII	120,000.00	100,000.00	-	-	ЗОГСОНГИ
7	Ар булаг XXIX	100,000.00	300,000.00	149,482,000₮	116,000,000₮	ЗОГСОНГИ



2019 онд Матад ХХ талбайд хийгдэж буй ажил

АМГТТГ-ын даргын А/19 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, тоногдсон өрмийн тоног төхөөрөмж, химийн бодисыг шийдвэрлэсэн.





1.5 САЯ.ТН/ЖИЛ

түүхий тос
Үйлдвэрий хүчин чадал



\$1.0 ТЭРБУМ

Шаардлагатай
хөрөнгө оруулалт



\$1.05 ТЭРБУМ/ЖИЛ

Борлуулалтын орлого
(ашиглалтад орсон жилээс эхлэн)



600 ажлын байр
шинээр бий болгоно



\$150.0 САЯ/ЖИЛ

Татвар (ашиглалтад
орсон жилээс эхлэн)



11 ЖИЛ Хөрөнгө оруулалтаа нөхөх
хугацаа

17,4%

Дотоод өгөөж /IRR/

\$138.9 САЯ/ЖИЛ

Ашиг (ашиглалтад орсон жилээс эхлэн)



Дорноговь аймаг
Алтанширээ
сум

Хийж гүйцэтгэсэн ажлууд:

- Засгийн газрын захиалгаар Унгар улсын Евройл компани УТЭЗҮ-ийг боловсруулж, 2016 оны 3 дугаар сард бэлэн болгосон.



Дамжуулах хоолойн трасс

Хоолойн урт: Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн аль нэг дээр байрших тос цуглуулах цэгээс шугам хоолойг татна. Дамжуулах хоолойн урт нь газрын тосны аль талбайгаас татахаас шалтгаалан 550-640 км байна.

Судалгааны шат: Геодезийн судалгаа хийгдсэн

Өрөмдлөгийн ажил: Нийт трассын дагуу 636 цооног өрөмдсөн.


Трассын дагуух гадаргын тогтоц: Трассын дагуух газрын гадаргуу нь тунамал хурдсын хуримтлалын өгөршилтийн үр дүнд үүссэн намхавтар уул толгод бүхий тал хээр болно. Дамжуулах хоолойн трасс нь төмөр зам болон хурдны замтай огтлолцохгүй.



Таних тэмдэг

Цахилгаан дамжуулах шугамтай ойрхон байршилтай хэсэг

Усан хангамж



Төслийн ТЭЗҮ-ийн тооцоо судалгаагаар газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн шат дамжлага, хөргөлтийн систем, унд ахуйн хэрэгцээнд нийт 106 л/сек ус шаардлагатай гэж тооцоолсон

2013-2014 онд 11 ш хайгуул-ашиглалтын цооног өрөмдсөнөөс 9ш цооногийг сонгож 40 орчим км дамжуулах хоолойгоор үйлдвэрийг усаар хангах

Хайгуулын дүнгээр В+С нөөцийн зэрэглэл нь 291л/сек буюу 9,2 сая м³/жил усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах боломжтойг тогтоосон.



Авто замын барилгын ажлын явц

17,5 км хүнд даацын автозам:

Ерөнхий гүйцэтгэгч – Батлан хамгаалах яам



БАТЛАН
ХАМГААЛАХЫН ЯАМ

- Хүнд даацын, тусгай зориулалтын асфальт болон бетон хучилттай авто замын ажлыг зураг төсөл, техникийн шаардлагын дагуу гүйцэтгэж **2019.09.15 гэхэд ашиглалтад оруулахаар** ажиллаж байна.
- БХЯ-ны 7780-р анги 170 хүн хүчний бүрэлдэхүүнтэй, зам барилгын 40 машин механизм, тоног төхөөрөмжтэй ажилласан.






Төмөр замын барилгын ажлын явц



27 км төмөр зам, 3,7 км холбоос зам
зам, төмөр бетон гүүр, туннель

Ерөнхий гүйцэтгэгч – “Улаанбаатар төмөр зам” ХХН


- 27 км салбар төмөр зам нь жилд 1.53 сая тн. ачаа тээвэрлэх зориулалттай төлөвлөгдсөн.
- Нийт 280 хүн хүч, 190 машин механизмтай ажиллаж 50 гаруй хувийн гүйцэтгэлтэй байна.
- Барилгын дээд бүтээцийн ажил ирэх 3 сараас үргэлжилж, **2019 оны 10-р сард хүлээлгэн өгөхөөр** ажиллаж байна.






ЦДАШ, дэд станцын барилгын ажлын явц

Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц:



Ерөнхий гүйцэтгэгч – Цахилгааны дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК (ЦДҮС ТӨХК)

- Эрчим хүч, эдийн засгийн хүрээлэн нь зураг төслийн ажил, Эрчим хүчний хөгжлийн төв нь барилгын хяналтын ажлыг гүйцэтгэсэн.
- Нийт 39 хүний бүрэлдэхүүнтэй 3 бригад, 15 техниктэй ажилласан.
- Ажлыг хүлээж авах **Техникийн комисс** ажиллаж байна.





Үйлдвэрийн талбай тэгшлэх, хашаа барих ажил


Үйлдвэрийн талбай тэгшлэх, хашаа б

Ерөнхий гүйцэтгэгч – Барилга, хот байгуулалт



БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ

- БХБЯ нь тус ажлын зураг төслийн ажлын даалгаврыг боловсруулж, аж ахуй нэгжүүдийн дунд тендер зарлаж, дүгнээд байна.
- Суурь инженерчлэлийн ажил эхэлж, салбар төмөр замын үйлдвэрийн талбайтай холбогдсон хэсэг, ачих/буулгах байгууламжийг гүйцэтгэсний дараа, талбай тэгшлэх эхлүүлэхээр төлөвлөж байна.



“Газрын тосны үйлдвэрийн хотхон”

“Газрын тосны үйлдвэрийн хотхоны төсөөлөл”



- Ирэх 4-5 жилд үйлдвэрийг барьж байгуулах олон тооны (оргил жилд **8000** орчим) гадаад, дотоодын ажиллагсадыг ажиллаж, амьдрах таатай нөхцөлөөр хангах зайлшгүй шаардлага гарсан.
- Кэмп сэрвис ажиллуулах нь өртөг зардал өндөртэй, эдийн засагч бус, түр зуурын шийдэл болно.
(Жишээ: $8000 \times 30\$ \times 365 \text{ хоног} = 87,6 \text{ сая } \$$)
- Ирээдүйд үйлдвэрт ажиллах **550** орчим инженер, техникийн ажиллагсадыг тохилог орон сууцаар хангах нь иргэдийн нийгмийн асуудлыг давхар шийдвэрлэх чухал ач холбогдолтой.



Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга-угсралтын ажил, ажиллах хүчин



**2020 онд 1000,
2021 онд 2000,
2022 онд 2000,
2023 онд 2000 орчим инженер, техникийн
болон туслах ажилчид орон нутагт ажиллах**




**Хотхон 500 айлын орон сууц барих бүтээн
байгуулалтын ажлыг 2022 онд багтаан
ашиглалтад хүлээлгэн өгхөөр ажиллаж
байна**



3. Газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг тогтвортой хангах, чанарын хяналтын тогтолцоог сайжруулах;

2018-2019.08 сарын хүртлэх газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ (тн)



Монгол Улсын хэмжээнд шатахуун импортлох тусгай зөвшөөрөлтэй 100 гаруй компани ОХУ, БНХАУ, БНСУ зэрэг 18 гаруй орнуудаас 2018 онд 1870,6 мянган тонн, 2019 оны эхний 8 сарын байдлаар 1405,3 мянга гаруй газрын тосны бүтээгдэхүүн импортлож, 101 агуулах, 1302 шатахуун түгээх станцаар дамжуулан монголын хэрэглэгчдийг шатахуунаар тасалдалгүй тогтвортой хангаж байна.




2.3.3.2 Газрын тосны бүтээгдэхүүний улсын болон аж ахуйн нэгжийн нөөц бүрдүүлэх, шатахууны үнийн хэлбэлзлийг зохицуулах зорилгоор Эрсдлийн сан байгуулах асуудлыг судлан эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх:



**УЛСЫН НӨӨЦ
12,7 МЯН. ТН**

- 2012 оны төсвийн хөрөнгө болон Засгийн газрын эрсдлийн сангийн хөрөнгөөр бүрдүүлсэн **12,7 мянган тонн** улсын нөөцийн шатахууныг аж ахуйн нэгжүүдтэй сэлгэх гэрээг 7 компанитай байгуулан хадгалж байна.



**КОМПАНИЙН НӨӨЦ
94,7-116,5 МЯН.ТН**

- Монгол Улсын Засгийн газрын **2017, 2018 оны тогтоолоор** газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээнд гарсан өөрчлөлттэй уялдуулан 2018 онд **94,7 мянган тонн, 2019 онд 116,5 мянган тонн** компанийн нөөц бүрдүүлэн ажиллаж байна. /2019 онд 26 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан./




2018-2019 ОНД ШАТАХУУНЫ ҮНИЙН ХЭЛБЭЛЗЛЭЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН АВЧ БУЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

- Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл”-ийн хуралдааныг 2018 оны 5 удаа, 2019 онд 1 удаа зохион байгуулж Хамтарсан зөвлөлөөс “Зөвлөмж” гаргасан.
- АМГТГ-аас 2018 онд болон 2019 он гараад дэлхийн газрын тосны үнэ болон дотоодын шатахууны жижиглэнгийн үнэ өссөн, буурсан онцгой нөхцөл байдалтай холбогдуулан 3 удаа хэвлэлийн бага хурал, төрийн байгууллага болон хувийн хэвшил, олон нийтийн байгууллага оролцсон хэлэлцүүлгийг 2 удаа зохион байгуулж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан иргэд, хэрэглэгчдэд ил тод, нээлттэй, үнэн бодит мэдээлэл өгөх арга хэмжээ авав.
- Үнийн Зөвлөлөөс гаргасан Зөвлөмжөөс:
- “Дэлхийн зах зээл дэх газрын тос болон хилийн үнэ, валютын ханшийн өөрчлөлт ороогүй тохиолдолд шатахууны жижиглэнгийн үнэнд үндэслэлгүйгээр өөрчлөлт оруулахгүй байх” зөвлөмжийг шатахууны худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд өгсөн.
- Автобензин, дизелийн түлшний татварын хувь хэмжээг оновчтой хэлбэрээр тогтоон зохицуулалт хийх, эрсдлийн сан байгуулах асуудлыг судлах, жижиглэнгээр борлуулж буй шатахууны үнийг эдийн засгийн зохистой түвшинд тогтвортой байлгах, түүнд хяналт тавих, мэдээлэл, сурталчилгаа хийх зөвлөмж гаргаад байна.

Засгийн газрын 2018-01-24-ний өдрийн 26 дугаар
ТОГТООЛ

*/А-80, Аи-92 автобензиний ОАТ-ыг тэгэлж, ДТ, 95 болон
түүнээс дээш автобензиний ОАТ-ыг хэвээр нь үлдээсэн/*



“Шатахууны үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан үнийн дарамтыг бууруулна” Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр



2.3.3.4. Нийлүүлэлтийг тогтвортой хангах талаар газрын тосны бүтээгдэхүүн экспортлогч орнуудтай Засгийн газрын түвшинд тохиролцох, импортын эх үүсвэрийг дотоодын үйлдвэрлэлийн хүчин чадалтай уялдуулах:



ОХУ-аас нийлүүлж буй шатахууны төлбөр төлөх хугацаа 45 хоног байсныг сунгаж 60 хоног болгох, Монгол Улсад сар бүр нийлүүлэх шатахууны доод хэмжээг улирлаар тогтоож байх хэлцлийг ОХУ-ын “Роснефть” компанитай хийж протоколд тусгаад байгаа. Мөн ОХУ-аас тээвэрлэж буй шатахууны төмөр замын тээвэрлэлтийн асуудлыг харилцан бичиг явуулж удаан хугацаанд шийдвэрлэдэг байсныг цахим хэлбэрээр буюу и-мэйлээр харилцаж богино хугацаанд шийдвэрлэдэг болсон.



БНХАУ, Казахстан зэрэг бусад орны шатахуун экспортлогч компаниудаас шатахуун импортлох эх үүсвэрийн судалгаа хийж, Замын-Үүд, Гашуунсухайт, Цагааннуур зэрэг боомтуудаар шатахуун импортлох ложистикийн асуудлуудыг шийдвэрлэхээр ажиллаж байна.



Шатахууны улсын болон компанийн нөөцийг нэмэгдүүлэх бодлого баримталж, улсын нөөцийн шатахуун хадгалах агуулах, савны асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авч байна. /Рашаант өртөөнд: 100,000 тн агуулах/



2.3.3.5. Дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэх замаар газрын тосны бүтээгдэхүүн түгээх байгууламжийн аюулгүй ажиллагааг хангах

2018-2019 ОНД ДЭВШИЛТЭТ ТЕХНИК ТЕХНОЛОГИ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НЭВТРҮҮЛЭН АШИГЛАЛТАД ОРСОН ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН ТҮГЭЭХ БАЙГУУЛАМЖУУД:



- Шатахуун түгээх станц
2018-45
2019-55



- Газрын тосны
бүтээгдэхүүний агуулах
2018-15
2019-7




2.3.3.6. Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дэргэдээ газрын тосны чанарын хяналтыг гүйцэтгэх лабораторийг итгэмжлэлийн үндсэн дээр байгуулах:



1. ТЭХЯ-ны харьяа ЭХСХТ-ийн химийн туршилт судалгааны төв лаборатори 2006-2008 он 2 жилээр
2. АМГ-ын нүүрсний туршилт судалгааны төв лаборатори 2011-2013 он 2 жилээр
3. АМГ-ын уул уурхайн шинжилгээ, туршилтын лаборатори 2013-2017 он 4 жилээр
4. АМГ-ын уул уурхайн шинжилгээ, туршилтын лаборатори 2014 оны 6 сард итгэмжлэлийн хүрээг хөрс усны бохирдлын шинжилгээгээр нэмэгдүүлсэн.
5. 2015 оны 12-р сарын 03-нд “Олон Улсын Лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага” (ILAC)-ын тэмдэгтийг хэрэглэх эрхийг авсан.
6. 2018 оны 5 дугаар сарын 10-нд Стандарт хэмжил зүйн газрын даргын А/145 тоот тушаалаар итгэмжлэлийн хүрээ өргөтгөж газрын тосны бүтээгдэхүүн автобензин, дизелийн түлшний чанарын шинжилгээ хийх эрхийг 2 жилийн хугацаатайгаар авсан.

2018 онд Улсын төсвийн хөрөнгөөр газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний тоног төхөөрөмжийн шинэчлэлт сайжруулалтыг хийсэн. Мөн лабораторийн тоног төхөөрөмж, шинжээч албан хаагчдын туршлага, ур чадварыг дээшлүүлэхээр БНСУ-ын К-Петро байгууллагтай хамтран ажиллаж байна.



Нүүрсний шинжлгээ:
1844 ширхэг дээж



Газрын тосны бүтээгдэхүүний
шинжилгээ:
250 ширхэг дээж



Хөрс, усны шинжилгээ:
182 ширхэг дээж

Нийт 2276 ширхэг дээжид чанарын шинжилгээг хийж үр дүнг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Улсын төсөвт 151,7 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.

Санал: Шатахууны чанарын шинжилгээ хийх мэргэжлийн тогтвор суурьшилтай ажиллах мэргэжилтэн бэлтгэж, дадлагажуулах,



Газрын тосны салбарын бодлогын хэрэгжилтийг хангахад тулгамдаж буй асуудлууд :

- Газрын тосны хайгуул ашиглалтын үйл ажиллагааг олон нийтэд зөвөөр сурталчилан танилуулахад төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудын дэмжлэг
- Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаа, хоорондын уялдаа холбоог сайжруулах;
- Орон нутгийн ажиллах хүчийг газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд түлхүү оролцуулах, орон нутгийн өгөөжийг нэмэгдүүлэх;
- Үндэсний мэргэжилтэн, мэргэшсэн ажиллах хүчийг бэлтгэх, тэдний ажил эрхлэлтийг үе шаттайгаар нэмэгдүүлэх



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА



ЧОЙБАЛСАН ХОТ | 2019